



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 6 сарын 22 өдөр

Дугаар 129

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.9, 62 дугаар зүйлийн 62.2, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн нийтэд санал болгон гаргах 12 сарын хугацаатай, жилийн 17.5%-ийн хүүтэй, нэг бүр нь 100,000.0 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 60,000.0 ширхэг “Сүү бонд” өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т, үүрэг болгож, арилжаа эрхлэх байгууллагын жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Нийтэд гаргасан өрийн хэрэгслийг 2017 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн дотор багтаан 70 ба түүнээс дээш хувийг анхдагч зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцох бөгөөд зарагдаагүй үлдсэн хэсгийг хүчингүйд тооцохоор тогтоосугай.

3. Өрийн хэрэгслийг нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааг амжилттай явагдсанд тооцох хүртэл арилжаанаас олсон орлогыг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

4. Өрийн хэрэгслийн арилжааны тайланг анхдагч зах зээлийн арилжаа дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан тус Хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж, үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад заасны дагуу зарцуулахыг “Сүү” ХК /Б.Гантулга/-д үүрэг болгосугай.

5. Өрийн хэрэгслийн борлуулалт, үндсэн болон хүүгийн эргэн төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/, Хяналт шалгалт, зохицуулалтын газар /Б.Ариунаа/-т тус тус даалгасугай.

6. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон гэж Хороо тооцсоноос хойш ажлын 5 хоногийн дотор өрийн хэрэгслийн барьцаа хөрөнгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн дансанд тусгаарлуулахыг “Голомт Капитал ҮЦК” ХХК /Э.Амарбаясгалан/, “Сүү” ХК /Б.Гантулга/-д тус тус үүрэг болгосугай.

7. Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөгдөх хугацааг үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссан өдрөөс тооцох ба үнэт цаас гаргагч нь

төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд зохих төлбөрийг барьцаа хөрөнгөөр хангуулахыг "Голомт Капитал ҮЦК" ХХК /Э.Амарбаясгалан/-д үүрэг болгосугай.

8. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН